



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

□ Албан тушаалын жагсаалт, ангилал, □
зэрэглэл шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” А/1649 дүгээр захирамж, Захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулах тухай А/304 дүгээр захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт шалгалтын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах зорилгоор орон тоонд нэмэгдсэн тул ажлын байрны жагсаалт, албан тушаалын ангилал, зэрэглэлийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан 2023 оны А/01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ